

ЕЛЮЙ ЧУЦАЙ, ЧАНЧУНЬ БОМБО ХОЁРЫН ХАРИЛЦАА

Н.Төмөр*

Чингис хааны Дундад Ази руу хийсэн аян дайны үед Елюй Чуцай, Чанчунь бомбо хоёр анх танилцаж харилцаа тогтоосон бөгөөд Чанчунь бомбыг Чингис хаантай уулзуулхад Елюй Чуцай нэлээд их үүрэг гүйцэтгэж тухайлбал, Чанчунь бомбыг залах Чингис хааны бичгийн төслийг тэрээр боловсруулжээ.¹ Чанчунь бомбын нэр нь Цю Чуцзи бөгөөд түүний бичгийн өргөсөн нэр нь Тунми юм.

Тэрээр 1148 онд Шаньдун мужийн Дэнчжоу тойргийн Цися сянь /сянь-засаг захиргааны нэгж/-ий Биндули хэмээх газарт төржээ. Цю Чуцзи багадаа бүтэн өнчирч, 19 настайдаа гэрээсээ гарч хувраг болж, улмаар 1168 онд 20 настай байхдаа Бомбын шашны нэг салбар болох “Цюаньчжэнь” /Үнэн төгөлдөр/ ёсны сургаалыг баримтлагч Ван Чуньян бомбын шавь болжээ.² “Цюаньчжэнь” ёсны суртал бол Бомбын шашны сургаалаар голлон “гурван мэргэний” /Күнз, Будда, Лаоцзы/ суртлын нийлбэр сургаал байсан ажээ. Үүний дараа Чанчунь бомбо Панци /одоогийн Шэньси мужийн Баоцзи сяний зүүн өмнө талд оршиж байсан/, Лунмэнь /одоогийн Шэньси мужийн Лун сяний баруун хойд талд оршиж байсан/ зэрэг газруудад 13 жил бясалгал үйлдэж, Бомбын ёсонд ихээхэн мэргэжиж, тэр үеийн алдарт аршийн нарын нэг болж, нэр цуу нь их дэлгэрчээ.³

* Доктор (Ph.D), ШУА-ийн Олон Улс Судлалын Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

¹ Елюй Чуцай. Өрнө этгээд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, доод дэвтэр. Елюй Чуцай нь 1190-1244 оны хооронд амьдарч байсан. Тэрээр Чингис, Өгэдэй хаадын дэргэд 30 шахам жил Их Монгол улсын төрд алба хашиж байжээ. Чжэу Яотин. Чингис хааны бүрэн цадиг /Чэцзисы хань цюаньчжэуань/, Бээжин, 1998, 431 дэх тал.

² Ли Чжичан. Чанчунь бомбын өрнө зүгт зорчсон тэмдэглэл /Чанчунь чжэцжэнь си ю цзи/, Хятадын түүхийн их толь бичиг /Чжунго лиши да цыдянь/, Шанхай, 1986, 117 дахь тал., Монголын түүх, бага нэвтэрхий толь, гуравдугаар дэвтэр, УБ., 2002, 191-192 дахь тал

³ Мөн тэнд

1219 онд Чингис хааны зарлиг ёсоор хятадын Бомбын /Даосын/ шашны их лам Чанчунь бомбо Цю Чуцзи, Ли Чжичан тэргүүтэй 18 итгэлт шавь нарыг дагуулан Чингис хаантай уулзахаар Шаньдун мужийн Лайчжоу нутгаас гарч Яньцзин /одоогийн Бээжин хот/, Сюаньдэ /одоогийн Хэбэй мужийн Сюаньхуа хот/ зэрэг Хятадын томоохон хотуудаар дамжин Үнэгэн даваагаар давж Монголын нутгаар урт аялал хийж 1221 оны арваннэгэн сард Дундад Азийн Самарканд хотод хүрэлцэн ирээд, тэнд өвлийг өнгөрүүлэн 1222 оны дөрвөн сард Гиндукуш /өнөөгийн Афганистаны нутаг дэвсгэрт оршино/ уул дахь Чингис хааны явуул ордонд хаанд бараалхан, Бомбын шашны ном сургаалыг танилцуулжээ.⁴

Чанчунь бомбыг Алтан улс, өмнөд Сүн улсын хаад олон удаа урьсан боловч тэрээр алинд ч очсонгүй. Харин Чингис хааны урилгыг хүлээн авч, Чанчунь бомбо итгэлт шавь нарын хамт урт замыг удаан хугацаанд туулж 1222 оны дөрвөн сард Гандукуш уул дахь Чингис хааны явуул ордонд хаантай хэд хэдэн удаа уулзаж, Бомбын шашны олон сургаалын мөн чанар, ёс дэглэм, их гүрнийг жолоодон удирдах арга ухаан, эзлэн авсан улс орнуудыг хэрхэн захирах, биеийн эрүүл мэндээ яаж хамгаалах, урт наслахад тус болох эм тан, дайн дажинаас үүссэн гай барцад, хараалыг зайлуулах зэрэг олон асуудлаар ярилцжээ.⁵

Чингис хаан, Чанчунь бомботой уулзахад хааны зарилгаар албан ёсоор орчуулагч хийж байсан Елюй Ахайн хамт Елюй Чуцай мөн орчуулагчаар ажиллаж байсан бололтой.⁶

Чанчунь бомбо Чингис хаантай уулзахад ямагт дэргэд нь байсан түүний шавь Ли Чжичан “Чанчунь бомбын өрнө зүгт зорчсон тэмдэглэл” зохиолдоо Чанчунь бомбын хийсэн аяллын талаар нэлээд тодорхой бичсэн боловч Гандукуш уул дахь Чингис хааны явуул ордонд болсон Чингис хаан, Чанчунь бомбо хоёрын уулзалтын тухай бичсэн зүйл бараг үгүй байлаа.

⁴ Ли Чжичан. Чанчунь бомбын өрнө зүгт зорчсон тэмдэглэл /Чанчунь чжэньжэнь си ю цзи/ “Монголын түүх, бага нэвтэрхий толь”, гуравдугаар дэвтэр, УБ., 2002, 190-191 дэх тал. Сайшаал. Чингис хааны товчоон, доод дэвтэр, Хөх хот, 1988, 833-854 дэх тал. Ш. Нацагдорж. Чингис хааны цадиг, УБ., 195-208 дахь тал. Чжэу Яотин. Чингис хааны бүрэн цадиг /Чэнцзисы хань цюаньчжэуань/, Бээжин, 1998, 432-446 дахь тал. “Хятадын түүхийн их толь бичиг” /Чжэунго лиши да цыдянь/, Шанхай, 1986, 76, 117 дахь тал. Rene Grousset. L'Empire Mongol par, E. De Boccard, Editeur, 1941, p.205-209; In the service of the khan, Edited by Igor de Rachewiltz, Hok-Lam Chan, Hsiao Ch'i-ch'ing and Peter W.Geier, Harrassowitz Verlag-Wiesbaden, 1993, p.143-145.

⁵ Ли Чжичан. Чанчунь бомбын өрнө зүгт зорчсон тэмдэглэл /Чанчунь чжэньжэнь си ю цзи/.

⁶ Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын эмхтгэл /Чжэанжэан цзюйши вэньцзи/, 12-р дэвтэр. Ли Чжичан. Чанчунь бомбын өрнө зүгт зорчсон тэмдэглэл /Чанчунь чжэньжэнь си ю цзи/. “Хятадын түүхийн их толь бичиг” /Чжэунго лиши да цыдянь/, Шанхай, 1986, 296 дахь тал.

Чингис хааны зарлиг ёсоор тэрхүү уулзалтын тухай тэмдэглэлийг маш нууц байдлаар хадгалж байгаад хожим хойно Чингис хааны шадар сайд, Хятадын асуудлыг эрхэлсэн бичээч⁷ Елюй Чуцай түүнийг эмхэтгэн “Бомбын суртлыг дэлгэрүүлсэн баярын хуримын тэмдэглэл” хэмээх нэртэйгээр нийтлүүлжээ.⁸

Ли Чжичан “Чанчунь бомбын өрнө зүгт зорчсон тэмдэглэл”-дээ түүний багш Цю Чуцзи Чингис хааны урилгыг хүлээн авч орон нутгаас анх мордсон, Монголын нутгаар дамжин Дундад Ази хүртэл олон сараар аялж, Чингис хаантай уулзсан бодит байдал хийгээд зам зуур үзэж сонссон зүйлс, нэн ялангуяа Монголын газар орон, зан заншил, хүн ардын аж амьдралын тухай нарийн тодорхой тэмдэглэн бичжээ.

Чанчунь бомбыг Чингис хаан чухам ямар зорилгоор урьсан, нутаг орондоо хаашаа ч явдаггүй, тэр ч байтугай өмнөд Сүн улс, Алтан улсын хаад тус тус урихад хөдөлгөөгүй тэр бомбо лам Чингис хааны ганц хоёр удаагийн урилгаар тийм хол замыг туулж явсаар ирж Чингис хаантай уулзсан явдал үнэхээр сонирхолтой зүйл билээ. Чанчунь бомбыг залж Бомбын шашны ном судар уншуулах талаар Чингис хаанд анх санал болгон дэвшүүлсэн хүн бол Чингис хааны хувийн эмч Лю Вэнь буюу Лю Чжунлу⁹ гэгч хүн байсан бөгөөд хожим нь энэ л хүнээр Чингис хаан шадар зөвлөгч Елюй Чуцайгаар бичүүлсэн залах бичгийг Чанчунь бомбод хүргүүлсэн билээ.¹⁰

Елюй Чуцай ямагт Чингис хааны дэргэд алба хашиж байсан болохоор ордны эмч Лю Вэнь Чингис хаанд Чанчунь бомбыг залах тухай санал дэвшүүлснийг анхнаас мэдэж, уг саналыг дэмжиж байсан билээ. Ийнхүү Елюй Чуцай Чингис хааны зарлиг ёсоор хааны нэрийн өмнөөс Чанчунь бомбыг залах бичгийг үйлдэж, Бомбын шашинтан Цю Чуцзи их ламыг эзэн Чингистэй уулзуулах явдалд дэмжлэг үзүүлэн идэвхтэй ороцож байсан нь учир шалтгаантай байжээ.

⁷ Ш. Бира. Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа, 3-р боть, УБ., 2001, 241 дэх тал. Бичээч буюу эртний хэллэгээр битэгчи хэмээх нь бидний одоогийн ойлголтоор зөвхөн бичээч буюу бичиг хэргийн эрхлэгч төдий бус, харин Их Монгол улсын засаг захиргааны томоохон тушаалын нэр байжээ.

⁸ Jiang Chuan. A textual research on whether Genghis khan was illiterate or not, Ulaan-hot, 1995, p.8

⁹ Ч. Далай. Монголын түүх, Их Монгол улс /1206-1260/, дэд дэвтэр, УБ, 1994, 126 дахь тал. Чжэу Яотин. Чингис хааны бүрэн цадиг /Чэнцзисы хань цюаньчжэуань/, Бээжин, 1998, 430 дахь тал. Лю Чжунлу бол Лю Вэний бичгийн өргөсөн нэр. Тэрээр Чингис хааны хувийн эмч, дуут зэв сайн хийдэг мэргэжилтэн байсан. Алтан улсын нийслэлийг дайлахад Лю Вэнь замчилж, Чингис хааны элчээр олон удаа зарагдаж байсан итгэлт хүн.

¹⁰ Елюй Чуцай. Өрнө этгээд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, доод дэвтэр. Чжэу Яотин. Чингис хааны бүрэн цадиг /Чэнцзисы хань цюаньчжэуань/, Бээжин, 1998, 430-431 дэх тал. Ч.Далай. Монголын түүх, Их Монгол улс /1206-1260/, дэд дэвтэр, УБ., 1994, 103 дахь тал.

Олон судлаачид Елюй Чуцайг Хятадын Күнзийн сурталтны хувьд Монголын хаадыг зөвхөн Хятадын уламжлалт суртлаар гэгээрүүлэхийг оролдож байсан мэтээр үзэж иржээ. Гэтэл сүүлийн үеийн судалгаанаас үзэхэд Их Монгол улсын хятан угсааны түшмэл Елюй Чуцайн төр улсыг засан төвхнүүлэх бодлогын гүн ухааны үндэс бол Күнз, Будда, Лаоцзы нарын буюу “Гурван мэргэний” суртлуудыг нэг ёсондоо хольж найруулсан үзэл байжээ.¹¹

Елюй Чуцай дээр дурдсан үзэл бодлоо хэрэгжүүлэх талаар хийсэн нэг томоохон ажил бол хааны хувийн эмч Лю Вэний саналыг дэмжиж, Чанчунь бомбыг залахыг Чингис хаанд зөвлөсөн бөгөөд үүнийг хэрэгжүүлэхийн тулд тэрээр ихээхэн хүчин чармайлт гаргажээ. Елюй Чуцай Чингис хааны шадар зөвлөгч, Хятадын асуудлыг эрхэлсэн бичээчийн хувьд хааны нэрийн өмнөөс Чанчунь бомбод явуулсан хоёр захидлыг төлөвлөн зохиожээ.¹² Гэхдээ, Елюй Чуцай хэдийгээр “Гурван мэргэний” суртал бол “тулгын гурван чулуу шиг ертөнц дахинаа баттай зогсох ёстой” хэмээн үзэж байсан боловч хэрэг дээрээ Күнз, Будда хоёрын суртлыг илүү дээдлэн үзэж, хос суртлын үндсэн дээр Их Монгол улсыг засан төвхнүүлэх учиртай хэмээн итгэн ажиллаж байжээ. Тэрээр “Төрийг Күнзийн суртлаар, сэтгэлийг Буддын сургаалаар жолоодон захирах ёстой” хэмээх үзлийг хатуу баримталж байсан билээ.¹³

Чанчунь бомбыг залахыг Елюй Чуцай ихэд дэмжиж, шаргуу ажиллаж байсан гол учир шалтгаан бол “Гурван мэргэний” суртлыг Чингис хаанд тайлбарлан танилцуулахад оршиж байсан хэмээн үзэж болно. Чанчунь бомбын баримталж байсан Бомбын /Даосын/ шашны нэг салбар болох “Цюаньчжэнь” /Үнэн төгөлдөр/ ёсны суртал бол “Гурван мэргэний” суртлын нийлбэр сургаал байлаа. Их Монгол улсын хаанд ёс суртахууны номлол зөвлөгөө үлэмж хэрэгтэй болохыг Елюй Чуцай өөрийн төлөвлөж Чанчунь бомбод явуулсан захидлууддаа онцлон тэмдэглэсэн байжээ.¹⁴

¹¹ Елюй Чуцай. Өрнө этгээд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, доод дэвтэр. Чжэу Яотин. Чингис хааны бүрэн цадиг /Чэнцзисы хань цюаньчжэуань/, Бээжин, 1998, 435 дахь тал

¹² Елюй Чуцай. Өрнө этгээд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, доод дэвтэр. Чжэу Яотин. Чингис хааны бүрэн цадиг /Чэнцзисы хань цюаньчжэуань/, Бээжин, 1998, 431 дэх тал.

¹³ In the service of the khan, edited by Igor de Rachewiltz, Hok-Lam Chan, Hsiao Ch'i-ch'ing and Peter W. Geier, Harrassowitz Verlag-Wiesbaden, 1993, p. 166-167

¹⁴ Чжэу Яотин. Чингис хааны бүрэн цадиг /Чэнцзисы хань цюаньчжэуань/, Бээжин, 1998, 431-434 дэх тал. In the service of the khan, Edited by Igor de Rachewiltz, Hok-Lam Chan, Hsiao Ch'i-ch'ing and Peter W. Geier, Harrassowitz Verlag-Wiesbaden, 1993, p. 143. Ли Чжэичан. Чанчунь бомбын өрнө зүгт зорчсон тэмдэглэл /хятад хэлнээс монгол хэлнээ хөрвүүлсэн Н. Ариунгуа/, УБ., 1997, 70-71 дэх тал.

Ийнхүү Дундад Азид байлдааны ажиллагаа ид явагдаж байх үед нь Чингис хааныг Бомбын шашны их ламтай уулзуулан Их Монгол улсын хааныг эртний мэргэдийн сургаалаар гэгээрүүлэхийг Елюй Чуцай ихэд хүсэн найдаж байсан боловч түүний хүсэл бодол талаар болов. Учир нь Чанчунь бомбыг хэд хэдэн удаа хүлээн авч Бомбын шашны ном сургаалыг сонссон ч Монголын их хаан эртний “Гурван мэргэний” сургаалыг төдий л ойшоон болгоосонгүй, өөрийн Бөөгийн мөргөлд үнэнч хэвээр үлджээ. Чингис хаан ертөнцийн их-соёл, иргэншлээс тасархай байсангүй, харин ч тэдгээрийн талаар эрдэмтэн мэргэдээс нь багагүй зүйлийг мэдэж байсан нь мэдээжийн хэрэг билээ. Их Монгол улсын хаан жанжны илдээ “Гурван мэргэний” сургаалын шидээр солихыг хүссэнгүй.

Нас сүүдэр 70 гарсан Чанчунь бомбо Чингис хааны урилгыг хүлээн авч алс холын газраас биеийн сул дорой, өвчин эмгэгийг үл хайхран Дундад Азид ирж хаантай уулзсан нь нэг талаар Чингис хааныг хүндэтгэсэн, нөгөө талаар Их Монгол улсын хаанд Бомбын суртлын аль ид шидтэй талыг танилцуулан бишрүүлж, Бомбын шашны лам нар, сүм хийдийг алба гувчуураас чөлөөлүүлэн, эрх дарх олж авснаар Бомбын шашны сургаалыг цаашид дэлгэрүүлэхэд хааны соёрхлыг олж авахыг зорилго болгосон бололтой. Харин Чингис хаан Чанчунь бомботой уулзаж, улс орноо хэрхэн жолоодон захирах асуудлаар ярилцаж, мөн өөрийн нас биеэ бодож Чанчунь бомбын ид шидээр мөнхийн рашаан гэгчийг олж хүртэхийг хүсч байлаа.

Елюй Чуцай, Чанчунь бомбо хоёрын хооронд удалгүй үл ойлголцох, тэр ч байтугай далдуур үл итгэлцэх ба тэмцэлдэх явдал үүсжээ. Елюй Чуцай, Чанчунь бомбо хоёрын хооронд зөрчил тэмцэл гарах болсон үндсэн шалтгааны талаар Елюй Чуцай “Өрнө этгээд зорчсон тэмдэглэл” зохиолдоо бичихдээ: “Миний бие Чанчунь бомбыг хүний хувьд хүндэтгэдэг. Харин түүний үзэл бодлыг таашаадаггүй. Учир нь бид хоёрын шашин суртал харилцан адилгүй” гэжээ.¹⁵

1222 оны дөрвөн сард Гандукуш уул дахь Чингис хааны явуул ордонд хаанд албан ёсоор бараалхахаас өмнө Чанчунь бомбо шавь нарын хамт 1221 оны өвлийг Дундад Азийн Самаркандад өнгөрүүлжээ.¹⁶ Тэрээр Самаркандад байх хугацаандаа Елюй Чуцайтай хэд хэдэн удаа уулзаж, нөхөрсөг дотно харилцаа тогтоосон ажээ.¹⁷

¹⁵ Елюй Чуцай. Өрнө этгээд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, доод дэвтэр. Елюй Чуцай Бурханы шашин, Чанчунь бомбо Цю Чуцзи Бомбын шашин шүтдэг байлаа.

¹⁶ Н.Ц.Мункуев. Китайский источник о первых монгольских ханах, Москва, 1965, стр. 17, Ли Чэсичан. Чанчунь бомбын өрнө зүгт зорчсон тэмдэглэл /Чанчунь чэсэпжэнь си ю цзи/-д бичсэнээр, Чанчунь бомбо шавь нарын хамт 1221 оны арваннэгдсэн сарын 8-нд Самаркандад хүрэлцэн иржээ.

¹⁷ Елюй Чуцай. Өрнө этгээд зорчсон тэмдэглэл /Си ю лу/, доод дэвтэр.

Елюй Чуцай, Чанчунь бомбо хоёр Самаркандаас олон удаа хөдөө агаар салхинд гарч яруу найргаар ном хаялцаж байсан тухай “Номхон даяанчийн зохиолын эмхтгэл”, “Чанчунь бомбын өрнө зүгт зорчсон тэмдэглэл” зэрэг ном зохиолд тус тус тэмдэглэн бичжээ.¹⁸ Елюй Чуцай, Чанчунь бомбо хоёрын хооронд шашин шүтлэг, үзэл суртлын талаар харилцан зөрөлдөж байсан боловч хувь хүний хувьд бие биеэ хүндэтгэж байлаа.

¹⁸ Елюй Чуцай. Номхон даяанчийн зохиолын эмхтгэл /Чжанжун цзюйши вэньцзи/, 5-р дэвтэр., Ли Чжичан. Чанчунь бомбын өрнө зүгт зорчсон тэмдэглэл /Чанчунь чжэньжэнь си ю цзи/.